



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 8/16

Ховд

Б.Чулуунцэцэгийг ажлаас чөлөөлөх тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 10.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын оператор Б.Чулуунцэцэгийн өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн тул 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн цахим оператороор томилогдож байгаа Б.Хишигзаяад үндсэн ажлыг нь хүлээлцэж, шинэ ажил үүргийн хуваарь, албан тушаалын тодорхойлолтыг батлуулж, ажил хүлээлцэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Б.Ганболд/-д үүрэг болгосугай.

3. Б.Чулуунцэцэгтэй холбогдох тооцоог хийж дуусгахыг Санхүү, аж ахуйн тасгийн Ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД